

“ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/187/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Х.Энхтуяа
Утас: 89182456 Цахим хаяг: enkhtuyakh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 95648028, 98828028
Цахим хаяг: zaya96884510@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/212.
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РЭНЧИНЛХҮМБЭ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.БАТДАВАА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Рэнчинлхүмбэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах материаллаг хэмжээний зөрчилтэй зүйл илэрсэн. Үүнд:

1. Сургуулийн хүүхдийн дотуур байранд стандартад заагдсанаас 1 тогооч илүү ажиллуулан 18,936.0 мянган төгрөгийн цалин олгож, төсвийн үр ашгийг бууруулсан,
2. Үдийн хоолны 27,792.8 мянган төгрөгийн зардлыг зарцуулахдаа батлагдсан норм нормативыг баримтлаагүй, хоол зүйч нь тогооч нарын хоолны цэсний мөрдөлтөд хяналт тавиагүй зөрчил тус тус илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д "Сургуулийн хоол зүйч сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг удирдан зохион байгуулж, суралцагч, ажилтан, эцэг, эхэд мэргэжлийн зөвлөгөөг өгнө", 9 дүгээр зүйлийн 9.1.4-д "сургуулийн хоол үйлдвэрлэлийн хүнсний хангамжийн талаар сургуулийн захиргаанд захиалга, хүсэлт, шаардлага гаргах", Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ, Ерөнхий шаардлага MNS 6781-2019 стандарт-ын 7.7-д "50 хүртэлх хүүхдэд 1 мэргэжлийн тогооч, түүнээс дээш бол туслах тогоочтой байна" гэж заасныг тус тус зөрчсөн ба "нийцсэн

бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс олох санхүүжилтийг 63,649.7 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 5,940.0 мянган төгрөгийн, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 6,858.8 мянган төгрөгийн зөрчил илэрч холбогдох шийдвэрийг гаргасан болно.

Бусад асуудлын хэсэг

Рэнчинлхүмбэ сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилго, 20 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 96.4 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан</i>		<i>/төгрөгөөр/</i>
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>828,430,618.78</u>	<u>700,235,046.46</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	456,061,843.78	355,902,881.68
Банкинд байгаа бэлэн мөнгө	456,061,843.78	355,902,881.68
Төгрөг	456,061,843.78	355,902,881.68
Төрийн сангийн харилцах	456,061,843.78	355,902,881.68
БАРАА МАТЕРИАЛ	366,718,775.00	338,599,824.51
Түүхий эд материал	510,000.00	510,000.00
Эм боох материал	510,000.00	510,000.00
Бэлэн бүтээгдэхүүн	30,600.460.00	30,061,500.00
Хангамжийн материал	322,958,315.00	292,848.324.51
Бичиг хэргийн материал	16,707,780.00	15,524,800.00
Аж ахуйн материал	32,686,275.44	27,438,345.44
Түлш, шатах тослох материал	20,996,038.00	25,399,038.00
Барилгын засварын материал	20,135,250.00	23,550,750.00
Хүнсний материал	42,975,679.00	34,838,478.75
Бусад хангамжийн материал	189,457,292.56	166,096,912.32
Мал амьтад	12,650,000.00	15,180,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,654,020,506.72</u>	<u>1,711,310,697.49</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,824,921,652.57	1,830,567,608.09
Биет хөрөнгө	1,515,834,306.72	1,577,924,497.49
Барилга, байгууламж, орон сууц	1,191,158,241.30	1,191,158,241.30
Хуримтлагдсан элэгдэл	-272,479,434.96	-302,003,327.40
Авто-тээврийн хэрэгсэл	68,765,000.00	68,765,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-50,566,458.18	-56,098,333.41
Машин тоног төхөөрөмж (компьютер)	640,070,226.72	610,055,318.23
Хуримтлагдсан элэгдэл	-251,925,761.93	-155,475,297.35
Тавилга, аж ахуйн эд хогшил	231,009,724.82	210,380,015.66
Хуримтлагдсан элэгдэл	-103,394,309.50	-39,499,073.20
Түүх соёлын дурсгалт зүйл	5,700,000.00	5,700,000.00
Бусад үндсэн хөрөнгө	13,047,925.00	10,368,125.00
Хуримтлагдсан элэгдэл	-4,547,925.00	-1,094,000.08
Ном	48,997,078.45	35,667,828.47
Биет бус хөрөнгө	138,186,200.00	133,386,200.00
Програм хангамж	600,000.00	600,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-350,000.00	-350,000.00
Бусад биет бус хөрөнгө	137,936,200.00	133,136.200.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,482,451,125.50</u>	<u>2,411,545,743.95</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>66,774,134.29</u>	<u>40,987,747.00</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24,275,638.29	21,509,274.00
Өглөг	24,275,638.29	21,509,274.00
Ажилчидтай холбогдсон өглөг	174,257.29	0.00

Бусад өглөг	24,101,381.00	21,209,274.00
Байгууллагад төлөх өглөг	24,101,381.00	21,209,274.00
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	42,498,496.00	19,478,473.00
Урт хугацаат зээл	42,498,496.00	19,478,473.00
Төгрөг	42,498,496.00	19,478,473.00
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	42,498,496.00	19,478,473.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,415,676,991.21	2,370,557,996.95
Засгийн газрын хувь оролцоо	2,415,676,991.21	2,370,557,996.95
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,517,378,361.70	1,517,378,361.70
Өмч: - төрийн	1,517,378,361.70	1,517,378,361.70
Хуримтлагдсан үр дүн	639,616,346.92	639,748,975.92
Өмнөх үеийн үр дүн	639,616,346.92	639,748,975.92
Тайлант үеийн үр дүн		-45,118,994.26
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	258,682,282.59	258,549,653.59
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,482,451,125.00	2,411,545,743.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,497,419,412.80	3,672,677,792.19
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	230,922,612.80	196,201,692.19
Нийтлэг татварын бус орлого	230,922,612.80	196,201,692.19
Төсөвт байгууллагын өөрийн орлого	221,066,468.80	190,446,123.43
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,202,800.00	5,169,300.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	420,000.00	955,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,680,000	
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	209,763,668.80	184,321,823.43
Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	9,856,144.00	5,033,971.76
Бусад орлого		721,597.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,266,496,800.00	3,476,476,100.00
Улсын төвлөрсөн төсвөөс	3,138,496,800.00	3,351,322,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,138,496,800.00	3,351,322,100.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,000,000.00	125,154,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага	128,000,000.00	125,154,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,086,405,287.35	3,697,144,869.57
УРСГАЛ ЗАРДАЛ	3,086,405,287.35	3,697,144,869.57
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,976,790,330.37	3,566,398,080.30
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,242,120,017.42	2,718,786,282.38
Цалин	1,397,922,825.77	1,604,163,285.83

Нэмэгдэл цалин	706,382,279.15	860,849,563.55
Унаа хоолны хөнгөлөлт		85,865,513.00
Урамшуулал	137,814,912.50	167,907,920.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	276,053,172.71	332,475,660.13
Тэтгэврийн даатгалын шимтгэл	187,871,726.55	223,459,440.79
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	22,233,855.26	27,166,386.61
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	13,750,446.70	17,671,049.56
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	10,439,428.85	12,835,756.69
Эрүүл мэндийн даатгалын хураамж	41,757,715.35	51,343,026.48
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,249,853.02	98,732,850.73
Гэрэл цахилгааны зардал	18,774,323.02	22,981,850.73
Түлш, халаалтын зардал	86,975,530.00	72,751,000.00
Цэвэр, бохир усны зардал	2,500,000.00	3,000,000.00
Хангамж, бараа материалын зардал	67,101,651.00	65,982,946.00
Бичиг хэргийн материал	27,837,620.00	875,000.00
Тээвэр, шатахууны зардал	30,988,531.00	21,138,164.00
Шуудан холбоо, интернетийн төлбөр		
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс		
Бараа материал актасны зардал		35,734,182.00
Нормативт зардал	98,946,801.00	138,347,630.25
Эм	104,200.00	
Хоол	98,842,601.00	138,347,630.25
Нормын хувцас, зөөлөн эдлэл		
Эд хогшил, урсгал засварын зардал	34,250,800.00	25,461,800.00
Урсгал засвар	34,250,800.00	25,461,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	27,277,455.79	27,794,715.03
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,491,000.00	5,169,300.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	17,786,455.79	22,625,415.03
Бараа үйлчилгээний бусад зардал	122,790,579.43	158,816,195.78
Бараа үйлчилгээний бусад зардал	24,707,543.10	14,806,000.00
Хичээл, сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал		17,489,480.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,083,036.33	126,520,715.78
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	109,614,956.98	130,746,789.27
Бусад урсгал шилжүүлэг	108,345,680.00	130,728,640.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	72,622,980.00	117,956,540.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	35,722,700.00	12,772,100.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,269,276.98	18,149.27
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,269,276.98	18,149.27
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	411,014,125.45	-24,467,077.38
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	2,353,500.12	20,651,916.88
Үнэ төлбөргүй гарсан зардал	243,500.12	20,651,916.88

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-2,353,500.12	-20,651,916.88
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	<u>408,660,625.33</u>	<u>-45,118,994.26</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,517,378,361.70	258,682,282.59	639,616,346.92	2,415,676,991.21
2	Тайлант үеийн үр дүн			-48,118,994.26	-48,118,994.26
3	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,517,378,361.70	258,549,653.59	594,629,981.66	2,370,557,996.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,276,119,600.00	3,483,321,997.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,622,800.00	6,845,897.00
Нийтлэг татварын бус орлого	9,622,800.00	6,845,897.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	9,622,800.00	6,124,300.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,202,800.00	5,169,300.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	420,000.00	955,000.00
Бусад орлого		721,597.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,266,496,800.00	3,476,476,100.00
Улсын төвлөрсөн төсвөөс	3,138,496,800.00	3,351,322,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,138,496,800.00	3,351,322,100.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	128,000,000.00	125,154,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	128,000,000.00	125,154,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	3,004,109,525.73	3,563,339,959.10
УРСГАЛ ЗАРДАЛ	3,004,109,525.73	3,563,339,959.10
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,883,085,968.75	3,433,132,129.83
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,238,523,229.87	2,711,898,088.51
Үндсэн цалин	1,348,513,934.55	1,537,326,080.11
Нэмэгдэл	755,663,422.14	929,951,577.23
Унаа хоолны хөнгөлөлт		85,706,740.27
Үр дүнгийн урамшуулал	134,345,873.18	158,913,690.90
Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	279,225,702.97	339,620,451.56

Тэтгэврийн даатгалын шимтгэл	190,593,857.46	231,348,565.57
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	22,158,011.58	27,056,395.89
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	11,078,955.79	13,881,290.01
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	11,078,955.79	13,466,961.43
Эрүүл мэндийн даатгалын хураамж	44,315,922.35	53,867,238.66
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	101,774,323.02	103,135,850.73
Гэрэл цахилгааны зардал	18,772,323.02	22,981,850.73
Түлш, халаалтын зардал	80,500,000.00	77,154,000.00
Цэвэр, бохир усны зардал	2,500,000	3,000,000
Нормативт зардал	105,256,130.00	130,210,430.00
Хоол, хүнс	105,256,130.00	130,210,430.00
Эд хогшил, урсгал засварын зардал	24,956,400.00	22,000,000.00
Урсгал засвар	24,956,400.00	22,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,654,555.79	32,417,615.03
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,868,100.00	9,792,200.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,786,455.79	22,625,415.03
Бараа үйлчилгээний бусад зардал	110,695,627.10	93,849,694.00
Бараа үйлчилгээний бусад зардал	90,143,327.10	77,543,194.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	20,552,300.00	16,606,500.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,023,556.98	130,207,829.27
Бусад урсгал шилжүүлэг	119,754,280.00	130,189,680.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	84,031,580.00	117,417,580.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	35,722,700.00	12,772,100.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,269,276.98	18,149.27
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,269,276.98	18,149.27
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	272,010,074.27	-80,017,962.10
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	64,768,500.00	20,141,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	64,768,500.00	20,141,000.00
Дотоод эх үүсвэрээр	64,768,500.00	20,141,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	64,768,500.00	20,141,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-64,768,500.00	-20,141,000.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	207,241,574.27	-100,158,962.10
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	248,820,269.51	456,061,843.78
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	456,061,843.78	355,902,881.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 5. төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
----------	------------	-----------	-------	------

<u>Татаас, санхүүжилтийн орлого</u>	3,991,231,400.00	3,483,321,997.00	507,909,403.00	87.5%
Улсын төсвөөс	3,414,971,800.00	3,351,322,100.00	63,649,700.00	98.5%
Орон нутгийн төсвөөс	125,154,000.00	125,154,000.00	0.00	99.2%
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	5,169,300.00	5,169,300.00	0.00	100.0%
Туслах үйл ажиллагааны орлого	955,000.00	1,676,597.00	-721,597.00	100.0%
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	-	-	0.00	
Урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх	444,981,300.00	-	444,981,300.00	
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</u>	3,991,231,400.00	3,483,321,997.00	507,909,403.00	87.5%
<u>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</u>	3,991,231,500.00	3,583,480,959.10	407,750,540.90	89.8%
<u>Ажиллагчидтай холбогдсон зардал</u>	3,375,596,000.00	3,051,518,540.07	324,077,459.93	90.4%
<u>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</u>	3,000,529,700.00	2,711,898,088.51	288,631,611.49	90.4%
Цалин	1,810,214,500.00	1,537,326,080.11	272,888,419.89	84.9%
Цалингийн тусгай нэмэгдлүүд	1,190,315,200.00	1,174,572,008.40	15,743,191.60	98.7%
<u>Нийгмийн хамгааллын шимтгэл</u>	375,066,300.00	339,620,451.56	35,445,848.44	90.5%
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	315,055,700.00	285,753,212.90	29,302,487.10	90.6%
Эрүүл мэндийн даатгалын хураамж	60,010,600.00	53,867,238.66	6,143,361.34	89.7%
<u>Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал</u>	103,154,000.00	103,135,850.73	18,149.27	99.9%
Гэрэл цахилгааны зардал	23,000,000.00	22,981,850.73	18,149.27	99.9%
Түлш, халаалтын зардал	77,154,000.00	77,154,000.00	0.00	100%
Цэвэр, бохир усны зардал	3,000,000.00	3,000,000.00	0.00	100%
<u>Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал</u>	354,499,000.00	298,618,739.03	55,880,260.97	84.2%
Хоол	140,027,500.00	130,210,430.00	9,817,070.00	92.8%

Бусад бараа үйлчилгээний зардал	116,119,700.00	97,684,194.00	18,435,506.00	84.1%
Мэдээллийн технологийн зардал	50,253,000.00	22,625,415.03	27,627,584.97	45.2%
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	16,306,500.00	16,306,500.00	0.00	100%
Урсгал засварын зардал	22,000,000.00	22,000,000.00	0.00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,792,300.00	9,792,200.00	100.00	99.9%
Урсгал шилжүүлэг	157,982,500.00	130,207,829.27	27,774,670.73	82.4%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	145,210,400.00	117,417,580.00	27,792,820.00	80.9%
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	12,772,100.00	12,772,100.00	0.00	100%
Төвлөрүүлэх шилжүүлэг		18,149.27	-18,149.27	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		456,061,843.78	-456,061,843.78	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		355,902,881.68	-355,902,881.68	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 194,506.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 194,506.8 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- ✓ Санхүүгийн байдлын тайланд 3,473.4 мянган төгрөгийн, үр дүнгийн тайланд 191,033.4 мянган төгрөгийн алдаа илэрснийг, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч залруулга хийсэн.

Аудитаар нийт 633,412.2 мянган мянган төгрөгийн зөрчил илрүүлэн, 2,940.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 500.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 629,972.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

Нэр бүхий хоёр ажилтанд 1,835.0 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон, няравт 1,105.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгосон зөрчлийг илрүүлэн төлбөрийн акт тогтоосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

3.2 Албан шаардлага

1. Сургуулийн 100 жилийн ойг тохиолдуулан төсвийн 500.0 мянган төгрөгөөр кино, контент хийлгэсэн.
2. Ахмадын сан байгуулж ажиллах талаар өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна...

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Тайлант онд 3,000.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг цэвэр бохир усны зардалд тайлагнасан нь Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай журам"-ыг зөрчсөн, "ангилал" батламж мэдэгдлийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж:

1. Батлагдсан төсвийг Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай журам"-ын дагуу зарцуулж тайлагнаж хэвших

Илрүүлэлт:

2. Эд хариуцагч нь 2025 оны 1- 12 дугаар сарын бараа материалын тайланг 17,178.1 мянган төгрөгөөр алдаатай гаргасан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.2-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байна" гэж заасныг зөрчсөн, "үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

2. Эд хариуцагчид бараа материалын тайланг тус сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргаж хэвших үүргийг хүргүүлэн, үр дүнг хянах;

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Тогооч нар дотуур байрны хүүхдийн хоолны 2,220.6 мянган төгрөгийн батлагдсан цэсэнд байсан хүнсний бүтээгдхүүний тоо, хэмжээг өөрчилсөн, тус зөрчлийг дотоод хяналтаар илрүүлж буруутай этгээдээр арилгуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "ерөнхий нягтлан бодогч хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.4-д ерөнхий нягтлан бодогч нь .нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад

нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасныг зөрчсөн ба “зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. Дотоод хяналтын нэгжид 2025 оны дотуур байрны болон үдийн хоолны цэсийг шалгах, цэсэнд байсан хүнсний бүтээгдхүүний тоо, хэмжээг өөрчилсөн тохиолдлыг илрүүлэн буруутай этгээдэд ажлын хариуцлага сайжруулах үүрэг өгч, биелэлтийг хянах

Илрүүлэлт:

2. Дотоод хяналтын нэгж нь тайлант онд 5 чиглэлийн 5 арга хэмжээнд хяналт хэрэгжүүлсэн гэсэн мэдээлэл ирүүлсэн боловч илэрсэн алдаа зөрчлийг нэгтгэж дүгнээгүй, зөвлөмж хүргүүлж, биелэлтийг тооцоогүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.7.3, 3.7.8 зэрэг заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж:

2. Дотоод хяналтын нэгжид төлөвлөсөн хяналт шалгалтыг бүрэн хийх, хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх, дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх үүргүүдийг өгч биелэлтийг тооцох

Төсвийн гүйцэтгэл, тайлагналтай холбоотой асуудал:

Илрүүлэлт:

1. Дотуур байранд стандартад заагдсанаас 1 тогооч илүү ажиллуулан 18,936.0 мянган төгрөгийг цалинд олгосон нь "Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ" Ерөнхий шаардлага MNS 6781-2019 стандартыг зөрчсөн, ба “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. “Дотуур байранд стандартад заагдсанаас 1 тогооч илүү ажиллуулсан зөрчлийг арилгах, “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ” Ерөнхий шаардлага MNS 6781-2019 стандартыг мөрдөж ажиллах

Илрүүлэлт:

2. Тээвэр шатахууны зардлын батлагдсан төсвийг 4,138.2 мянган төгрөгөөр төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

2. Тээвэр шатахууны зардлын зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, батлагдсан төсөвтөө багтаан зарцуулах,

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Үдийн хоолны зардлыг зарцуулахдаа батлагдсан норм нормативыг баримтлаагүй, хоол зүйч нь тогооч нарын хоолны цэсний мөрдөлтөд хяналт тавиагүй, сурагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээ хийгээгүй байна. Энэ нь Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6.6-д “Сургуулийн хоол зүйч сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг удирдан зохион байгуулж, суралцагч, ажилтан, эцэг, эхэд мэргэжлийн зөвлөгөөг өгнө”, 9.1.4-д “сургуулийн хоол үйлдвэрлэлийн хүнсний хангамжийн талаар сургуулийн.

сургуулийн захиргаанд захиалга, хүсэлт, шаардлага гаргах” гэснийг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. Үдийн хоолны тогооч нарт хоол зүйчийн боловсруулсан технологийн карт, цэсийг үйл ажиллагаандаа мөрдөж, баримтжуулж хэвших, хоол зүйчид сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зохистой дадал нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих үүргийг хүргүүлэн, биелэлтийг тооцох

Илрүүлэлт:

2. Шилэн дансны цахим системд батлагдсан төсвийг 379,590.2 мянган төгрөгөөр, худалдан авах ажиллагааны тайланг 32,179.4 мянган төгрөгөөр, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 144,936.9 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1,1,6.1.6, 6.4.5-д заасан мэдээллийг энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй..

Өгсөн зөвлөмж:

2. Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ, аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Хүснэгт 6. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын тайлан болон үр дүнгийн тайланд алдаа илэрсэн	1	194,506.8	1	194,506.8			1	194,506.8				
Дүн	1	194,506.8	1	194,506.8			1	194,506.8				

Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
шатахууны зардлыг цэвэр бохир усны зардалд тайлагнасан	1	3,000.0					1	3,000.0
Хоёр ажилтанд цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон	1	2,940.0	1	2,940.0				
Тогооч нар дотуур байрны хүүхдийн хоолны батлагдсан цэсэнд байсан хүнсний бүтээгдхүүний тоо, хэмжээг өөрчилсөн	1	2,220.6					1	2,220.6
Эд хариуцагч нь 2025 оны 1-12 дугаар сарын бараа материалын тайланг алдаатай гаргасан.	1	17,178.0					1	17,178.0
Байгууллага нь 4,138.1 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан.	1	4,138.1					1	4,138.1
Дотуур байранд стандартад заагдсанаас 1 тогооч илүү ажиллуулсан	1	18,936.0					1	18,936.0
Дүн	6	48,412.7	1	2,940.0			3	45,472.7

Хүснэгт 8. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илэрсэн.								
Үдийн хоолны зардлыг зарцуулахдаа батлагдсан норм нормативыг баримтлаагүй, хоолны цэсний мөрдөлтөд тавих дотоод хяналт хангалтгүй	1	27,792.8					1	27,792.8
Дотоод хяналтын нэгжийн ажлын үр дүн хангалтгүй байна	1	0.00					1	0.00
Шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулаагүй	1	556,706.6					1	549,522.1
Төсвийн хөрөнгөөр кино, контент хийлгэсэн.	1	500.0			1	500.0		

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй	1				1			
Дүн	4	584,999.4			1	500.0	3	584,499.4